



НИЙСЛЭЛИЙН НИЙГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Ахмадын хөлбөмбөгийн тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах ахмадын хөлбөмбөгийн тэмцээнийг 2017 оны 10 дугаар сарын 07-15-ны өдрүүдэд Монголын Хөлбөмбөгийн холбоо, Монголын Спорт сонирхогчдын мастеруудын холбоо, "Их талын дуулиан" ТББ-тай хамтран Эрчим клубын талбайд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.040.000 /нэг сая дөчин мянга/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны спортын уралдаан тэмцээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.


4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Спортын хөгжлийн хэлтсийн дарга /С.Саранцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны даргын
2017 оны *есдүгээр* сарын *29*-ны өдрийн
А/46 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Ахмадын хөлбөмбөгийн тэмцээнийг зохион
байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 15 x 10.000 төг = 150.000 төг 15 x 8.000 төг = 120.000 төг 15 x 6.000 төг = 90.000 төг	360.000
2.	Шүүгчдийн ажлын зардал: /12 хүн x 1 өдөр x 20.000 төг/	240.000
3.	Өргөмжлөл	50.000
4.	Медаль	360.000
5.	Анонс, цом	30.000
ДҮН:		1.040.000

Боловсруулсан

С.Саранцэцэг

Хянасан

О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны даргын
2017 оны *есдүмөр* сарын *29*-ны өдрийн
А/46 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Ахмадын хөлбөмбөгийн тэмцээний
шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|-----------------------|----------------|
| 1. Ерөнхий шүүгч | Б.Батсайхан |
| 2. Нарийн бичиг шүүгч | Б.Сэлэнгэ |
| 3. Шүүгч | Ц.Энхтайван |
| 4. Шүүгч | Д.Далантай |
| 5. Шүүгч | Н.Үүрийнцолмон |
| 6. Шүүгч | Д.Мягмарсүрэн |
| 7. Шүүгч | С.Наранцэцэг |
| 8. Шүүгч | Д.Ганцог |
| 9. Шүүгч | А.Амармэнд |
| 10. Шүүгч | Н.Хүрэлбаатар |